



## ЭРХИЙН МЭДЭГДЭЛ

Цагдаад баривчлагдан хоригдсон хүнд олгох  
Террорист үйл ажиллагаа  
(бүлэг зүйл анги Эрүүгийн хариуцлагын хуулийн 63-1, 706-73 ба  
706-88 дугаар)

**Доорхи мэдээлэл таны ойлгодог хэл дээр танд өгөгдөнө.**

**Та цагдаад баривчлагдан хоригдох хугацаанд үг баримтыг хадгалж болно**

Таныг террорист үйл ажиллагаа үйлдсэн ба үйлдэхийг завдсан хэмээх нэг буюу хэд хэдэн сэжиглэх шалтгаан байгааг үндэслэн цагдаа баривчлан хорих болсныг танилцуулсан болно.

Хорин дөрвөн цагаар үргэлжилж болох цагдаад баривчлагдан хоригдох явцад та уг хэргийн талаар байцаалт өгнө.

Та өөрийн цагдаад баривчлагдан хоригдох байдалд хүргэсэн хэргийн шалтгаан, огноо ба үйлдсэн газрыг мэдэх эрхтэй.

Уг хугацаа өнгөрсний дараа, Улсын прокурор буюу хяналтын прокурор нь таны хорих хугацааг дахин нэмэлт хорин дөрвөн цагаар сунгахаар шийдвэр гаргаж болно. Прокурор тантай биечлэн уулзах боломжгүй бол видео хурлаар орно.

Онцгой тохиолдолд, хэрэв мөрдөн байцаалтын явц юмуу хэрэг бүртгэл явуулах явцын шаардлагыг харгалзан, Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч юмуу Хяналтын прокурор 2 удаа 24 цагаар цагаар нэмж сунгаж болно.

Хэрэв мөрдөн байцаалтыг анхны дөчин найман цагийн дотор дуусгахааргүй нь тодорхой болсон бол Улсын прокурор Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч юмуу Хяналтын прокурорын хүсэлтийн дагуу цагдаад баривчлагдан хоригдох хугацааг зөвхөн нэг удаа дөчин найман цагаар сунгах шийдвэрийг гаргана.

Хэрэв мөрдөн байцаалтын анхны үр дүн нь эсвэл цагдаад баривчлагдан хоригдох нь Франц улсад буюу өөр гадаад улсад террорист үйлдэл хийх эрсдэл өндөр байгааг нотолсон буюу гадаад олон улсын хамтран ажиллагаа тусламж авах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч болон Улсын прокурорын зааварчилгааны дор эсвэл Хяналтын прокурорын хүсэлтийн дагуу шалтгаанаа тодруулан бичгээр үйлдсэн бол цагдаад баривчлагдан хоригдох хугацааг нэг удаа шинэчлэн нэмэлт хорин дөрвөн цагаар сунгах болсон шийдвэрийг гаргана.

Цагдаад баривчлагдан хоригдох хугацаа дууссаны дараа Улсын прокурор эсвэл хяналтын прокурорын шийдвэрээр энэ Прокурор тантай биечлэн уулзах эсвэл суллах шийдвэр гаргаж болно. Эхний тохиолдолд та өөрийн хорих хугацаа дууссан цагаас тоолон 20 цагийн дотор шүүх хуралд орно. Үүнд таны түр хоригдох хугацаа 72 цагаас илүү байсан тохиолдол орохгүй.

**ТАНЫ БУСАД ЭРХИЙГ МЭДЭЭЛЖ БАЙНА :**

**Хэсэг хүмүүст хэлүүлж мэдэгдэх эрхтэй**

Та н өөрийн хамт амьдардаг хүн, эсвэл цусан төрлийн хүн, төрсөн ах эгч эсвэл таны асран хамгаалагч, эсвэл хууль ёсны хариуцагчдаа цагдаад баривчлагдан хоригдож байгаа талаар утсаар мэдэгдэх хүсэлт гаргаж болно.

Та өөрийн ажил олгогчдоо хэлүүлж болно.

Хэрэв та гадаадын иргэн бол та өөрийн улсын консулын газарт мэдэгдэж болно.

Улсын прокурор эсвэл хяналтын прокурор нь мөрдөн байцаалтын хэрэгцээ шаардлагын улмаас, уг хүсэлтийг хүлээн авахгүй, татгалзаж болно.

Онц хүнд байдалд ороогүй л бол, хүсэлттэй танилцаад, 3 цагийн дотор гурван цагийн дотор арга хэмжээ авагдана.

Таны цагдаад баривчлагдан хоригдож хугацаа ерэн зургаа дахь цагаас илүү үргэлжлэх тохиолдолд та ойр дотны хэн нэгэндээ ерэн зургаа дахь цагаас эхлэн мэдэгдэх хүсэлтийг гаргаж болно. Улсын прокурор эсвэл хяналтын прокурор нь мөрдөн байцаалтын хэрэгцээг шаардлагын дагуу тус хүсэлтэнд дахин татгалзсан хариу өгч болно.

#### **Эмчээр үзлэг хийлгэх**

Та цагдаад баривчлагдан хоригдох хугацааныхаа эхэнд буюу уг хоригдолт сунгагдсан тохиолдолд эмчээр үзлэг хийлгэх хүсэлт гаргаж болно. Цагдаад баривчлагдан хоригдох хугацаа сунгагдах нь тодорхой болон батлагдсан үед танд зайлшгүй эмчийн үзлэг хийх бөгөөд та шинээр эмчийн үзлэг хийлгэх хүсэлт тавьж болно.

#### **Та дуугарахгүй чимээгүй байх эсвэл эсвэл асуултууданд хариулан байцаалтаа өгч болно.**

Та өөрийн биеийн байцаалтаа хэлсний дараа байцаалт өгөхдөө доорхи эрхийг эдэлнэ:

- мэдүүлгээ өгөх,
- Танаас асуусан асуултууданд хариулах,
- үг дуугарахгүй байх

#### **Өмгөөлөгчтэй ярилцах**

##### **- Өмгөөлөгчийн сонголт:**

Цагдаад баривчлагдан хоригдсоны эхнээс та өөрийн сонголтоор өмгөөлөгч сонгон түүний туслалцааг авч болно. Хэрэв та өмгөөлөгчөө сонгох боломжгүй эсвэл таны өмгөөлөгчтэй холбоо барьж чадахгүй байгаа тохиолдолд улсаас томилсон үнэгүй өмгөөлөгчтэй ярилцах хүсэлт гаргах эрхтэй.

Таны өмгөөлөгчийг таны хэлүүлсэн хүн томилж болно: уг тохиолдолд та өмгөөлөгчийг зөвшөөрч буй эсэхээ батлах ёстой.

##### **- Өмгөөлөгчийн тусламж:**

Өмгөөлөгч нь доорхи эрхтэй:

- таньтай 30 минутын хугацаанд ярилцах. Хугацаа сунгасан тохиолдолд та сунгалтын эхээр түүнтэй дахин давтан уулзаж ярилцах хүсэлт гаргаж болно.
- хэрэв та хүсвэл тэр таны байцаалтууд болон нүүрэлдүүлэхэд байлцаж болно.

##### **- Оролцооны хугацаа:**

Мөрдөн байцаалтын ажиллагааны явцаас шалтгаалан, байцаалтыг нэн даруй хийх шаардлагатай бол Улсын прокурор эсвэл хяналтын прокурор бичгээр шалтгаанаа тодруулан хүсэл гаргасан бол, хуулинд заагдсан өмгөөлөгчийн ирэх 2 цагийн хугацааг харгалзан үзэлгүй шүүд байцаалтаа эхлүүлж болно.

Таны өмгөөлөгчийн оролцоо нь 72 цагаас илүүгүй хугацаагаар хойшлогдож болох ба үүнд хүндэтгэсэн шалтгаан заагдсан байх ёстой.

#### **Хэлмэрчийн туслалцаа**

Хэрэв та франц хэл ойлгодоггүй ба ярьдаггүй бол та байцаалтын үед өмгөөлөгчтэй

ойлголцохын тулд үнэгүйгээр хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

**Цагдаад баривчлагдан хорих хугацааг дуусгавар болгохыг шаардах эрх**

Та Улсын прокуророос буюу Цагдан хорих болон суллах асуудлыг шийдвэрлэх эрх бүхий шүүгч ба хяналтын прокурораас цаашдын цагдаад хорих хугацааг сунгасан тохиолдолд уг арга хэмжээг авахгүй байхыг хүсэж болно.

**Таны хавтаст хэргийн зарим материалд хүрэх боломж**

Таны буюу таны өмгөөлөгчийн хүсэлтийн дагуу таны цагдаад хорих хугацааг сунгахын өмнө та доорхи зүйлсүүдтэй танилцаж болно:

- таныг цагдаад хорих болсон мэдэгдлийн протоколтой танилцах,
- танд үзлэг хийсэн эмчийн эмнэлгийн тодорхойлолтуудтай танилцах,
- танаас авсан байцаалтуудын протоколтой танилцах.